**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 22 өдөр Дугаар А/60 Улаанбаатар хот

Дүүргийн Хууль, Эрх зүйн ажлын 2023 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн хэмжээнд зохион байгуулах Хууль, Эрх зүйн ажлын 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг цаг хугацаанд нь чанартай зохион байгуулж, холбогдох зардлыг тухай бүр санхүүжүүлж, үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2023 он ажил\захирамж

1123000183

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 03 сарын 22 –ны өдрийн А/60
дугаар Захирамжийн хавсралт

ДҮҮРГИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР 2023 ОНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Эрх зүйн сургалтын нэр | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрэх үр дүн | Хугацаа (улирал) | Хариуцах нэгж, байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| НЭГ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | |
| 1 | Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулиудын төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх хэлэлцүүлэг зохион байгуулах, санал авах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | 90% | -Хэлэлцүүлэг зохион байгуулагдсан байх<br>-Үр дүнг нэгтгэн зохион байгуулсан байх | Жилдээ | ЗДТГ, Төрийн байгууллагууд |
| 2 | Төрийн албаны тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журам, зааврын талаар сургалт зохион байгуулах | Зохион байгуулах сургалтын тоо/хүн | 2/50 | 3/50 | -Төрийн албаны хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байх | I, III,IV улирал | Засаг даргын Тамгын газар |
| 3 | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын талаар сургалт зохион байгуулах | Зохион байгуулах сургалтын тоо/хүн | 1/25 | 2/60 | -Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хяналт, үр дүнг тооцсон байх | I,III улирал | Засаг даргын Тамгын газар |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Архивын тухай хууль болон албан хэрэг хөтлөлтийн заавар, журмын талаар сургалт зохион байгуулах | Зохион байгуулах сургалтын тоо/хүн | 3/178 | 3/120 | -Төрийн албан хаагчийн албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт сайжирсан байх | I, II, IV улирал | Засаг даргын Тамгын газар |
| 5 | Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага болон иргэд, олон нийтэд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | Зохион байгуулах сургалтын тоо/хүн | - | 1/50 | -Иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байх<br>-Хууль сурталчлах ажлыг зохион байгуулсан байх | III улирал | Багахангай, Налайх дүүргийн шүүхийн Тамгын газар |
| 6 | Худалдан авах ажиллагааны мэргэшсэн гэрчилгээг олгох сургалт зохион байгуулах | Зохион байгуулах сургалтын тоо/хүн | 1/27 | 1/30 | -Мэргэшүүлэх сургалт зохион байгуулагдсан байх | II улирал | Худалдан авах ажиллагааны алба |
| 7 | Зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх, хуульд заасан хугацаа, болзол, журмыг мөрдөх, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хуулийн дагуу хянан шийдвэрлэх, албан хаагчдыг сургах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах | Зөвшөөрөл олгосон ААНБ-ын тоо | - | 3 | -Хууль журмын дагуу зөвшөөрөл олгосон байх<br>-Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байх<br>-Үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж ажилласан байх | Жилдээ | ЗДТГ, Аж ахуйн нэгж байгууллагууд |
| 8 | “Хариуцлагатай сонгогч” сонгуулийн хууль тогтоомжийн сургалтыг зохион байгуулах | Зохион байгуулах сургалтын тоо/хүн | - | 2/20 | -Сургалт зохион байгуулагдсан байх<br>-Албан хаагчдын мэдлэг, чадвар | Жилдээ | Сонгуулийн хороодод ажиллах албан хаагчид |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дээшилсэн байх | | |
| 9 | "Боловсролын харилцаанд оролцогч эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн эрх үүрэг" сэдэвт сургалтыг зохион байгуулах | Зохион байгуулах сургалтын тоо/хүн | - | 1/100 | -Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн байх | II улирал | "Хангай" цогцолбор сургууль |
| 10 | Хуулийн салбарын байгууллагуудын хууль сурталчлах "Нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 2/100 | 2/150 | -Иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээлэл дээшилсэн байх | I, III улирал | Засаг даргын Тамгын газар |
| 11 | Монгол улсын Үндсэн хуулийн 100 жилийн түүхт ойн баярыг угтан Монгол Улсын Үндсэн хуулийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | Зохион байгуулах арга хэмжээний тоо/ хүн | - | 3/120 | -3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулагдсан байх | I, II, IV улирал | Засаг даргын Тамгын газар |
| 12 | Шинээр батлагдсан хууль тогтоомжоор гарын авлага бэлтгэх, шторк, сурталчилгааны материалыг иргэдэд хүргэх | Гарын авлага, сурталчилгааны материалын тоо | - | 12/300 | -Холбогдох хууль тогтоомжийн гарын авлага бэлтгэсэн байх<br>-Олон нийтэд сурталчилсан байх | Жилдээ | ЗДТГ, Төрийн байгууллагууд |
| 13 | Хууль, эрх зүйн үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 90% | 90% | -Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тооцсон байх | II, IV улирал | ЗДТГ, Төрийн байгууллагууд |
| 14 | Гэмт хэрэг зөрчилд холбогдсон төлбөрийн чадваргүй этгээдэд үнэ төлбөргүй "Эрх зүйн | Байгуулах төвийн тоо/ хүн | - | 1/5 | -"Эрх зүйн туслалцаа үзүүлэх" төв байгуулагдсан байх<br>-Иргэдэд эрх зүйн | Жилдээ | ИТХ, ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | туслалцаа үзүүлэх” ажлыг судлах, эхлүүлэх | | | | туслалцаа үзүүлсэн байх | | |
| 15 | Дүүргийн иргэд, ААНБ-ын ажилтан, албан хаагчдын дунд Хууль сурталчлах зорилгоор “Дэвжээ” тэмцээн зохион байгуулах | Арга хэмжээнд оролцох баг/тамирчдын тоо | - | 5/25 | -Тэмцээн зохион байгуулагдсан байх<br>-Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн байх | IV улирал | ИТХ, ЗДТГ, ГБХЗХХ |
| 16 | “Хүний эрхийн өдөр”-ийн тэмдэглэн өнгөрүүлэх, “АХА” танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулах | Арга хэмжээний тоо /хүн | - | 1/25 | -Арга хэмжээ зохион байгуулагдсан байх<br>-Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн байх | IV улирал | ИТХ, ЗДТГ |
| ХОЁР. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | |
| 17 | “Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд багш, ажилтны ёс зүйн, сахилга, захиргааны зөрчил, тэдгээрийг танин мэдэх, шалган шийдвэрлэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусган хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулах | Төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж буй сургууль, цэцэрлэгийн тоо/хүн | - | 3/50 | -Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжиж, хүүхэд холбогдсон гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан байх | I улирал | ИТХ, Боловсролын хэлтэс |
| 18 | Хороодын Хамтарсан багийг чадавхжуулах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 | 5 | -Хамтарсан багийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан байх | IV улирал | ИТХ,ЗДТГ, Хороод |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | ХЗДХС-ын нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний хэрэгжилтийг хангаж ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | 90% | -Гэрээний хэрэгжилт хангагдсан байх | II, IV улирал | ЗДТГ, Төрийн байгууллагууд |
| 20 | Хороодын Хамтарсан багийн “Асуудал, шийдэл” ур чадварын уралдааныг зохион байгуулах, нийслэлийн шатанд оролцуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо/хүн | 2/10 | 2/10 | -Хамтарсан багийн гишүүдийн ур чадвар сайжирсан байх | III улирал | ЗДТГ, Хороод |
| 21 | Эрүү, иргэний анхан шатны шүүх хуралдааныг дүүрэгт зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | - | Төрийн үйлчилгээ иргэнд хүрсэн байна. | Тухай бүр | ИТХ, ЗДТГ |
| 22 | Дүүрэгт ашиглагдаж байгаа хяналтын камеруудын арчлалт, хамгаалалтыг сайжруулж, хэвийн үйл ажиллагаа хангах, шаардлагатай гудамж талбай, авто замыг камержуулах | Хэвийн үйл ажиллагааг хангасан камерын тоо/Шинээр суурилуулсан камерын тоо | -/4 | 4/8 | -Гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурч, гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэн байх | II-IV улирал | ИТХ, ЗДТГ, Дүүргийн ААНБ, ЦХ |
| 23 | Зөрчлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хамтарсан шалгалтыг зохион байгуулж, үр дүнд үнэлэлт дүгнэлт хийх, | Хяналт шалгалтын тоо | - | 1 | -Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, нэгж байгууллагын оролцоо нэмэгдэж, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурсан байх | III улирал | Цагдаагийн хэлтэс |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цаашид авах арга хэмжээг тодорхойлох | | | | | | |
| 24 | Байгууллагын хэмжээнд “Гэмт хэрэг, зөрчилгүй хамт олон” аяныг зохион байгуулах, хэрэгжүүлэх | Зохион байгуулах арга хэмжээний тоо/байгууллага | 1/25 | 1/25 | -“Гэмт хэрэг, зөрчилгүй хамт олон” болсон байх | Жилдээ | ИТХ, ЗДТГ, дүүргийн ААНБ |
| 25 | “Аюулгүй орчин – Амар тайван дүүрэг” болзолт уралдааныг зохион байгуулах, хэрэгжүүлэх | Уралдаанд оролцсон албан байгууллагын тоо/шинээр суурилуулсан камер, хаяг реклам, гэрлэн чимэглэлийн тоо | - | 8/8 | -Гэр хорооллын гудамж талбай, олон нийтийн газар, орц, аж ахуйн нэгж, байгууллагын гадна болон дотор талыг камержуулалд, хаяг реклам, гэрлэн чимэглэл нэмэгдсэн байх | II-III улирал | ИТХ,ЦХ, дүүргийн ААНБ |
| 26 | “Эрүүл орчин – Иргэдийн сайн сайхан” 3 дугаар шатны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах /Урам төсөл/ | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 2 | -Архины асуудалтай иргэн, гэр бүлийн хэрэглээ тодорхой хэмжээнд буурсан, 1 иргэн архинаас татгалзсан байх | I-IV улирал | ИТХ, ЗДТГ, ТББ |